

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

ИЛТГЭХ ХУУДАС

“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын хариуцаж буй
Нийтийн бие засах газар /City toilet/-ын ашиглалтын үйл ажиллагаанд
явуулсан хяналтын ажлын тухай

2017 оны 02 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Хотын Ерөнхий менежерээс өгсөн үүрэг чиглэлийн дагуу “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын хариуцаж буй Нийтийн бие засах газрын ашиглалтын үйл ажиллагаанд Аудит, дотоод хяналтын хэлтсийн Дотоод хяналтын мэргэжилтэн Т.Туул 2017 оны 02 дугаар сарын 11-ний өдөр хяналт шалгалт явуулсан ба үйл ажиллагаанд тус газрын Зам цэвэрлэгээний мэргэжилтэн Б.Мөнхцоозыг хамрууллаа.

Хариуцсан нийтийн бие засах газруудын ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзэж шалгасан ба тухайн газруудын үйл ажиллагаатай холбоотой гэрээ, холбогдох баримт бичгүүдтэй танилцаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Улаанбаатар сан ОНӨААТҮГ-ыг газрыг татан буулгах тухай” 45 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/382 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатар сан” ОНӨААТҮГ-т бүртгэлтэй 917,559,684,3 төгрөгийн үнэ бүхий нийт 11 нийтийн бие засах газрыг “НҮУБН” ОНӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлсэн байна. Үүнээс Багануур, Багахангай, Налайх дүүрэгт 3 нийтийн бие засах газрыг хариуцуулан өгсөн ба “НҮУБН” ОНӨААТҮГ-т 8 газрыг хүлээлгэн өгсөн байна.

Мөн 2015-2016 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдсан 11 бие засах газрыг ашиглалтад хүлээн авч, “НҮУБН” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч, 10 бие засах газрыг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн байна. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 15 нийтийн бие засах газрын 45,176,727 төгрөгний элэгдлийн зардал гарсан бөгөөд үлдсэн 4 бие засах газраас 2 нь байршлын хувьд тохиромжгүй учраас ашиглагдаагүй, 2 нь улсын комисс хүлээж аваагүй учир элэгдлийн зардал тооцоогүй.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр нийтийн эзэмшлийн гудамж талбайд тавигдсан нийтийн бие засах газрын ашиглалт, үйлчилгээг хариуцуулахаар “Хамтран ажиллах 17/06-06 дугаар гэрээ”-г байгуулсан байна. Гэрээнд нийт 19 бие засах газрыг ажиллуулан гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр ашиглалтын зардал болох нийт 126,540,000 /19 газарт 1 сар бүр 10,545,000/ төгрөг тусгасан байна.

Нийтийн бие засах газрын үйл ажиллагааны орлого / 2016 он/

Д/д	Байршил	9/10 сар	11 сар	12 сар
1	Чингэлтэй дүүрэг 18 хороо 7-н буудал	355,000	108,300	26,600
2	Сонгинохайрхан дүүрэг 8 хороо Баянхошууны тойргийн автобусны буудал	53,000	22,000	16,000

3	Хан-Уул дүүрэг 1 хороо 120 автобусны буудал	171,500	301,000	161,000
4	Сонгинохайрхан дүүрэг 13 хороо СХД-ЭМНэгдэл	143,400	66,300	85,200
	Дүн	722,900	497,600	288,800
Нийт 1,509,300 төгрөг				

Нийт 2016 оны 09 сараас - 2016 оны 12 дугаар сарын дуустал 1,509,300 төгрөгийн орлого олсон байна.

Нийтийн бие засах газрын түрээсийн орлого / 2016 он /

Д/д	Байршил	Орлого
1	Сүхбаатар дүүрэг 8 хороо УБ зочид буудал	189,000
2	Чингэлтэй дүүрэг 2 хороо Бөмбөгөр худалдааны төв	550,000
3	Сүхбаатар дүүрэг 11 хороо 100 айл	1,267,000
4	Сүхбаатар дүүрэг 8 хороо Сүхбаатарын талбайн Хонхтой цэцэрлэгт	200,000
	Нийт	2,206,000

Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ нь 2014 онд 99,196,600 төгрөгийн, 2016 онд 58,646,064 төгрөгийн санхүүжилт авсан ба 2015 онд санхүүжилт аваагүйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

Нөхцөл байдлын шинжилгээ.

“Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын ашиглалтыг хариуцаж байгаа нийт 19 нийтийн бие засах газраас 2-ыг нь комисс ашиглалтад хүлээж аваагүй ба 17 газрын байнгын хэвийн ажиллагааны ашиглалтыг хариуцан ажиллаж байна.

Дээрх 17 газрын 5-ыг Хот тохижилтын газар өөрсдөө, 10-ыг нь түрээс болон ашиглалтын гэрээгээр, нийт 15 газрыг ажиллуулж, **88,2% нь** байнгын ажиллагаатай байгаа бол байршил муутай, үйлчлүүлэгч ордоггүй нөхцөл шалтгаанаар 2-ыг нь ажиллуулаагүй, түр зогсоосон байна. /Хавсралт 1. Нийтийн эзэмшлийн бие засах газрын байршил, ашиглалтын талаарх судалгаа мэдээлэл/

Хот тохижилтын газар нь УБЗАА-аас ашиглалтын зардал 10,545,000 төгрөгийн санхүүжилт авахаас 2017 оны 01 дүгээр сард өөрийн хариуцаж буй 5 газрын ашиглалтын зардалд 8,250,060 төгрөгийн санхүүжилт авахаар гүйцэтгэлээ гаргаж өгсөн байна. /Хавсралт 2. Гэрээний санхүүжилтийн зарцуулалтын задаргаа/

Ашиглагч байгууллага нь газрын байршил, үйлчилгээний орлогын байдлаас хамаарч түрээсийн төлбөрийн нөхцлийг ялгаатай тогтоосон байх ба тухайн оны 10.01- 05.01 хүртэл түрээсийн төлбөр авахгүйгээр түрээсийн гэрээ хийгдсэн байна.

Дараах үндсэн нөхцлөөр “Ашиглалтын болон Түрээсийн гэрээ” байгуулсан байна.

- Түрээсийн болон ашиглалтын гэрээтэй иргэдэд дагалдах эд хогшлийг актаар шилжүүлэх, хүлээн авсан эд хөрөнгийн засвар, үйлчилгээ, цэвэрлэгээ, харуул хамгаалалт, түүнчлэн барилгын инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, засвар үйлчилгээний зардлыг бүрэн хариуцах.

- Ашиглалтын зардлууд болох цахилгаан, халаалт, халуун ус, цэвэр ус, бохир усны зардал болон ажилтны цалингийн зардлыг өөрсдөө бүрэн хариуцах нөхцөлтэйгээр хийсэн байна.

Иргэд, үйлчлүүлэгч төдийлөн үйлчлүүлэхгүй, байршлын хувьд тохиромжгүй байрлалд байх 2 газрыг цаашид энэ хэвээр ажиллуулах боломжгүй, түрээслэх эзэн байхгүй, элэгдэлд орж, өнгө үзэмж муудах, ашиглалтын шаардлага хангахгүй нөхцөл бүрдэж нийслэлийн өмч үргүйдэж байна. Үүнд:

- СБД 17-р хороо, Дамбадаржаагийн хийдийн хашаа, БЗД, 16-р хороо, Батлан хамгаалахын их сургуулийн хашаан дотор,
- Сонгинохайрхан дүүргийн 27-р хороо, ЗДТГ байрлах бие засах газрыг ХТГ үндсэн хөрөнгөдөө бүртгэсэн ба цахилгааны тусгай зөвшөөрөлгүй ХХК нь барьсан учир КТП-г улсын комисс хүлээж аваагүйгээс ажиллах боломжгүй байгаа бөгөөд шүүхийн шатанд явж байгаа болно.

Мөн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны Чингэлтэйн эцэст байрлах нийтийн бие засах газар /НБЗГ/-ыг 2016 онд улсын комисс ажиллаж хүлээж авсан ч албан ёсоор хүлээлгэж өгөөгүй бөгөөд 2017 онд ХТГ-т өгөх мэдээтэй байна.

Хот тохижилтын газар нь ашиглагдахгүй байгаа дээрх 4 газраас бусад 15 бие засах газарт 45,176,727 төгрөгийн элэгдэл хорогдлын зардалд тооцуулсан байна.

Дүгнэлт:

Хот тохижилтын газар ОНӨААТҮГ нь дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд нийтийн бие засах газрын ашиглалт, үйлчилгээг хэвийн явуулах, байнгын тогтмол ажиллагаатай байлгах тал дээр зохих хэмжээнд анхаарч, УБЗАА-наас олгож буй санхүүжилтийн хүрээнд өөрсдөө заримыг хариуцаж, ашиглах боломжтой бусад газруудыг иргэд аж ахуй нэгжтэй түрээс болон ашиглалтын гэрээний нөхцлөөр гэрээлэх байдлаар нийт 15 газар буюу 88,2%-ийг байнгын тогтмол ажиллагаатай байлгаж байна.

УБЗАА-тай байгуулсан гэрээний санхүүжилтийн хуваарилалт нь хариуцаж буй бүх /19/ газрыг бүрэн ажиллуулах зардалд хүрэхгүй тул дээрх зохицуулалтын арга хэмжээг авч, нийслэлийн иргэдэд байнгын тогтмол үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажилласан нь сайшаалтай.

Гэвч энэ нь дээрх объектыг байнгын ажиллагаатай байлгах, ахуйн үйлчилгээг иргэдэд хүргэх түвшинд авч буй зохих арга хэмжээ боловч цаашид энэ байдлаар зохицуулахад хүндрэлтэй бөгөөд нийслэлийн өмчийг ариг гамтай, зориулалтын дагуу бүрэн ашиглах хүрээнд зохих менежментийн арга хэмжээ авч ажиллах шаардлагатай нь харагдаж байна.

Нийтийн бие засах газрыг байгуулахаар төлөвлөхдөө эрэлт хэрэгцээ шаардлагад тулгуурлалгүй, иргэд үйлчлүүлэгчид төдийлөн үйлчлүүлэхгүй тохиромжгүй байршилд байгуулсан байгаа нь нийслэлийн өмч хөрөнгийг үргүйдүүлэх, ажиллагаагүй объектуудад ашиглагч байгууллага хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал тооцуулах, эвдрэл, гэмтэл гарах зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна. Мэдээллээр /дам сургаар/ анх төлөвлөсөн газарт газрын маргаан үүссэнээс дээрх газруудад шилжүүлэн байршуулах замаар зохицуулсан нь энэхүү нөхцөл байдалд хүргэсэн байх магадлалтай.

Ахуй үйлчилгээний нэгж салбарт ялангуяа нийтийн бие засах газрын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандарт горим байхгүйгээс тус хяналт шалгалтын ажлын явцад эрх зүйн хүрээнд тодорхой шаардлага тавихад

хүндрэлтэй, зөвхөн ашиглалтын түвшинд харагдах байдал, ашиглагч байгууллагаас (ХТГ) түрээслэгч байгууллагуудын гэрээгээр зохицуулсан харилцааны хэрэгжилт, ашиглалтын хэвийн ажиллагаатай байлгаж буй түвшинд үнэлэлт дүгнэлт өгч, ажлын явцад ашиглагч байгууллага, үйлчилгээний нэгжид зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Судалгаанаас үзэхэд ашиглагч байгууллагад бүртгэлтэй 19 НБЗГ-ын 6 нь дулаанд, 19 нь цахилгаанд, 18 нь цэвэр усанд, 13 нь бохир усны шугам сүлжээнд холбогдсон байх ба шугам сүлжээнд холбогдсон байх ба дулааны шугам сүлжээнд холбогдоогүй 13-ыг халаалтын цахилгаан хэрэгслэлээр халааж ашиглаж байна.

МУ-ын Их Хурлын тогтоолоор 2016 онд батлагдсан Эрүүл ахуйн тухай хуулинд “ариун цэврийн байгууламж”-ийг эрүүл ахуйн нөхцөлд, шаардлагын дагуу байгуулж ашиглах, асуудлаар зарим заалт тусгагдаж, улмаар **хуулийн 4.7-д** заасны дагуу Стандартчиллал хэмжилзүйн үндэсний зөвлөлийн тогтоолоор “Нүхэн жорлон. угаадасны нүх. техникийн шаардлага стандарт MNS 5924:2015” батлагдаж, төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжид тавигдах стандарт шаардлага тодорхой болсон байна. Одоогоор төвлөрсөн инженерийн байгууламж, шугам сүлжээнд холбогдсон болон бие даасан ариутгах татуургын системтэй инженерийн хийцтэй байгууламж буюу нийтийн бие засах газрын үйл ажиллагааг тодорхой зохицуулсан стандарт, дүрэм журам байхгүй байна.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас, бодлого, зохицуулалтын хүрээнд:

1.“Хүн амын ахуй үйлчилгээ 2020 хөтөлбөр”-ийг боловсруулахдаа нийтийн бие засах газруудын үйлчилгээг сайжруулах, тэдгээрт тавигдах шаардлага, үйлчилгээний стандарт горим буюу эрх зүй, арга зүйн орчныг тодорхой болгох талаар тодорхой заалт тусгах, /ХХҮХ/

2.Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил, хотын өмчийг бүрэн ашиглах хүрээнд зохих менежментийн арга хэмжээ авах, ашиглагч байгууллагыг тодорхой чиг үүргээр хангах, /ТХХУХ/ Үүнд:

- Гэр хороололд байрлах ашиггүй газруудын үйлчилгээний хэлбэрийг өргөтгөх /дэд бүтцийн байдлаас шалтгаалж/, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан ажил үйлчилгээ нэвтрүүлэх чиглэлээр судалж, тодорхой ажлыг хэрэгжүүлэх. Тухайлбал халуун ус, үсчин, хими цэвэрлэгээ, угаалга, ахуйн үйлчилгээ гэх мэт.
- ХТГ-т гэрээний хүрээнд олгож байгаа санхүүжилтийг дээрх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлд зарцуулж болох, талаар судалж, тодорхой арга хэмжээ авах, /НӨХГ-тай үндсэн хөрөнгийн зориулалтыг өөрчлөх тохиолдолд ямар арга хэмжээ авахыг судалж, шийдвэрлэх замаар/
- Бүхэлд нь менежментийн гэрээгээр аж ахуй нэгж, иргэнд ашиглуулах, эсхүл ашиглагч байгууллагын дэргэд ашиглалтын захиргаа байгуулах чиглэлээр уг асуудлыг тухайлчлан хариуцуулж болох,
- Бусад гэх мэт.

3.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас ашиглагч байгууллага “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-тай ашиглалт, үйлчилгээг хариуцуулахаар байгуулж байгаа “Хамтран ажиллах” гэрээний нөхцөлд эрх, үүргийг тодорхой тусгах, санхүүжилтийн задаргааг хавсралтаар баталж, хэрэгжилтэд хяналт тавих,

Хот тохижилтын газар буюу ашиглагч байгууллагын зүгээс:

1.Түрээсийн гэрээний хугацаа дууссан, ашиглалт нь хэвийн байгаа газруудад түрээслэгч нартай гэрээг сунгах, /Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Сүхбаатарын талбайн хонхтой цэцэрлэгт байрлах Нийтийн бие засах газрын түрээслэгчтэй гэрээг сунгах, өөрсдөө хариуцах боломжгүй болон ашиглалтыг хэвээр үргэлжлүүлэх тохиолдолд/

2.Түрээсээр болон ашиглалтын гэрээгээр ажиллуулж байгаа нийтийн бие засах газруудын ашиглалт хамгаалалтын байдалд анхаарч, эвдрэл гэмтэл гаргахгүй байх, нийслэлийн өмчийг ариг гамтай хэрэглэх, засвар, арчлалтыг гэрээнд заасны дагуу хийж буй эсэхэд хяналт тавьж ажиллах,

3.Түрээслэгч болон ашиглалтын гэрээтэй газруудын гэрээний хэрэгжилтэд, ялангуяа хөрөнгө, техник, хэрэгслэлийн бүрэн бүтэн байдал, үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд хяналт тавих, гэрээний зохицуулалтаар тодорхой үүрэгжүүлэх.

4.Цаашид түрээсийн болон ашиглалтын гэрээний нөхцлөөр ажиллуулах тохиолдолд байгууламж, тэдгээрийн эд хөрөнгийг зүй зохистой, ариг гамтай ашиглах, үйлчилгээг иргэдэд чанартай хүргэх, цэвэрхэн ая тухтай орчинд үйлчлүүлэх нөхцлийг хангуулах түвшинд зохих үйлчилгээг үзүүлэх, хог хаягдал /бохирдсон цаас, бусад/-ыг зайлуулах, тээвэрлүүлэх асуудлаар хог тээвэрлэлтийн байгууллагатай гэрээтэй ажиллах, зэрэг нөхцлүүдийг тодорхой тусгах, гэрээний хэрэгжилт үр дүнг тооцох.

5.Нийслэлийн өмчид бүртгэлгүй байгаа 2 газрыг ашиглалтад эцэслэн хүлээж авах, үндсэн хөрөнгөд тусгуулах, байнгын ажиллагаатай байлгахад анхаарч, эзэнжүүлэх,

6.Нийтийн бие засах газруудыг бүрэн ажиллуулах, иргэдийн ая тухтай үйлчлүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэх, ашиглалтыг сайжруулан үйл ажиллагааны орлогоороо зардлаа бүрэн нөхөх хэмжээнд асуудлыг шийдвэрлэх хүрээнд санал санаачлага гарган ажиллах, ажиллуулахгүй байгаа бие засах газрыг цаашид хэрхэх талаар холбогдох байгууллага, нэгжүүдтэй санал солилцох, шийдвэрлэх. Үүнд:

- Гэр хороололд байрлах ашиггүй газруудын үйлчилгээний хэлбэрийг өргөтгөх /дэд бүтцийн байдлаас шалтгаалж/, иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан ажил үйлчилгээ нэвтрүүлэх чиглэлээр судалж, тодорхой ажлыг хэрэгжүүлэх. Тухайлбал халуун ус, үсчин, хими цэвэрлэгээ, угаалга, ахуйн үйлчилгээ гэх мэт. /НӨХГ-тай үндсэн хөрөнгийн зориулалтыг өөрчлөх тохиолдолд ямар арга хэмжээ авахыг судалж, шийдвэрлэх замаар/
- Бүхэлд нь менежментийн гэрээгээр аж ахуй нэгж, иргэнд ашиглуулах, эсхүл ашиглагч байгууллагын дэргэд ашиглалтын захиргаа байгуулах чиглэлээр уг асуудлыг тухайлчлан хариуцуулах гэх мэт.

ТАНИЛЦСАН:

АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.РЭГЗЭДМАА

..... оны дугаар сарын

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Т.ТУУЛ

..... оны дугаар сарын

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН БИЕ ЗАСАХ ГАЗРЫН БАЙРШИЛ,
АШИГЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ

2017 оны 05 дугаар сарын 08

Улаанбаатар хот

	Байршлын талаарх мэдээлэл		Ашиглалтын талаарх мэдээлэл		Дэд бүтэц шийдвэрлэгдсэн байдал				Шугамд холбох боломжтой
			Газрын гэрчилгээтэй эсэх	Байгууламжийн талбайн хэмжээ	Дулаан	Цахилгаан	Цэвэр ус	Бохир ус	
1.	Сүхбаатар дүүрэгт 4 байршилд	17 дугаар хороо, Дамбадаржаа хийдийн хашаан дотор	-	6м x 7м		+	+		Бохир усны шугамд
2.		8 дугаар хороо, Сүхбаатарын талбайн Хонхтой цэцэрлэгт	+	6м x 7м		+			-
3.		11 дүгээр хороо, 100 айл	-	3м x 12м	+	+	+	+	-
4.		8 дугаар хороо,	-	6м x 7м		+	+	+	-

		УБ зочид буудал							
5.	Сонгино-хайрхан дүүрэгт	13 дугаар хороо, СХД-ЭМНэгдэл	+	6м x 7м	+	+	+	+	-
6.	4 байршилд	5 дугаар хороо, Саппоро автобусны буудал	+	6м x 7м		+	+	+	Дулааны шугамд
7.		8 дугаар хороо, Баянхошууны тойргийн автобусны буудал	+	6м x 7м		+	+		-
8.		27 дугаар хороо, СХД-ЗДТГ	+	6м x 7м		+	+	+	Дулааны шугамд
9.		Баянгол дүүрэгт	16 дугаар хороо, Баруун 4 зам	+	6м x 7м	+	+	+	+
10.	3 байршилд	1 дүгээр хороо, Төмөр зам авто вокзал	+	6м x 7м		+	+	+	-
11.		13 хороо, Өргөө кино театр	+	6м x 7м	+	+	+	+	-
12.	Баянзүрх дүүрэгт	3 дугаар хороо, Зүүн 4 зам	+	6м x 7м	+	+	+	+	-
13.	3 байршилд	16 дугаар хороо, Батлан хамгаалахын их сургуулийн хашаан дотор	-	6м x 7м		+	+	+	Дулааны шугамд 300-400м
14.		8 дугаар хороо,	+			+	+	+	-

		Ботаник автобусны буудал		6м x 7м					
15.	Чингэлтэй дүүрэгт 4 байршилд	18 дугаар хороо, 7-н буудал	+	6м x 7м		+	+		Бохирын шугамд
16.		16 дугаар хороо, Хайлаастын эцэс	-	6м x 7м		+	+	+	-
17.		15 дугаар хороо, Чингэлтэйн эцэс	-	6м x 7м		+	+		-
18.		2 дугаар хороо, Бөмбөгөр худалдааны төв	+	6м x 7м	+	+	+	+	-
19.	Хан-Уул дүүрэгт 1 байршилд	1 дүгээр хороо, 120 автобусны буудал	-	3м x 12м		+	+		Дулааны шугам
Нийт дүн				Гэрчилгээтэй: 12, Гэрчилгээгүй: 7.	6	19	18	13	<ul style="list-style-type: none"> • Дулаанд холбох боломжтой: 4, • Бохирын шугамд: 2

ТАНИЛЦСАН:
АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
... оны ... дугаар сарын

Ц.РЭГЗЭДМАА

СУДАЛГАА ЖАГСААЛТ НЭГТГЭСЭН:
АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТУУЛ

**НИЙТИЙН БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ЗАРДЛЫН ТООЦОО,
СУДАЛГАА
/2017 оны жилийн байдлаар/**

ДД	Зардлын нэр	Нийт өртөг /төгрөгөөр/
1	Цалин	183,334,080.00
2	НДШ	23,833,430.40
3	Ашиглалтын зардал: <ul style="list-style-type: none"> • Халаалт, дулаан. • Цахилгаан, • Засвар үйлчилгээ • Хог хаягдлын тээвэрлэлт, • Цэвэр бохир ус, • Бохир соруулах, • Хангамжийн материал, • Газрын төлбөр 	142,594,937
4	Элэгдлийн зардал	209,689,939
Нийт зардал		559,452,386.40

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ТООЦООЛОЛ

Д/д	Хөрөнгө нэр	Хөрөнгийн байршил	Өдөр тутмын орлого	Ажиллах өдөр	Сарын орлого	Жилийн орлого
1	НБЗГ: Баянгол сити тойлет	БГД16-р хороо /Баруун 4 замын автобусны буудал/	5000	24	120000	1440000
2	НБЗГ: НБЗГ-ын барилга	СХД 13-р хороо /СХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл/	5000	24	120000	1440000
3	НБЗГ: Чингэлтэй сити тойлет	ЧД 2-р хороо /Бөмбөгөр худалдааны төв/	5000	24	120000	1440000
4	НБЗГ: Хан-Уул сити тойлет	ХУД 1-р хороо /120-ын автобусны буудал/	5000	24	120000	1440000
5	НБЗГ: НБЗГ-ын барилга	БГД 13-р хороо /Өргөө кино театр/	5000	24	120000	1440000
6	НБЗГ: Баянзүрх сити тойлет	БЗД 3-р хороо /Зүүн 4 замын автобусны буудал /	5000	24	120000	1440000
7	НБЗГ: Сүхбаатар сити тойлет	СБД 11-р хороо /100 айлын автобусны буудал/	5000	24	120000	1440000
8	НБЗГ: Сүхбаатар сити тойлет	СБД 8-р хороо /УБ зочид буудал/	5000	24	120000	1440000
9	НБЗГ: НБЗГ-ын барилга	ЧД 18-р хороо /Долоон буудал/	5000	24	120000	1440000
10	НБЗГ: НБЗГ-ын барилга	БГД 1-р хороо /Төмөр замын авто вокзал/	5000	24	120000	1440000
11	НБЗГ: НБЗГ-ын барилга	БЗД 16-р хороо /Батлан хамгаалахын их сургуулийн хашаан дотор/	5000	24	120000	1440000
12	НБЗГ: НБЗГ-ын барилга	БЗД 8-р хороо /Ботаник автобусны буудал /	5000	24	120000	1440000
13	НБЗГ: НБЗГ-ын барилга	СХД 8-р хороо /Баянхошуу тойргийн автобусны буудал/	5000	24	120000	1440000
14	НБЗГ: Сонгинохайрхан сити тойлет	СХД 27-р хороо /СХД-ийн ЗДТГын хажууд/	5000	24	120000	1440000
15	НБЗГ: НБЗГ-ын барилга	СХД 12-р хороо /Соппара автобусны буудал/	5000	24	120000	1440000
16	НБЗГ: НБЗГ-ын барилга	СБД 17-р хороо /Дамба даржаа хийдийн хашаан дотор/	5000	24	120000	1440000
17	НБЗГ: НБЗГ-ын барилга	ЧД 18-р хороо /Чингэлтэйн эцсийн буудал/	5000	24	120000	1440000
18	НБЗГ: Чингэлтэй сити тойлет	ЧД 15-р хороо /Хайлаастын эцсийн буудал/	5000	24	120000	1440000
19	Эко-ОО	СБД-08 хороо	5000	24	120000	1440000
Нийт 19 НБЗГ-ын орлогын дундаж			95000	456	2280000	27,360,000

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН БИЕ ЗАСАХ ГАЗРЫН БАЙРШИЛ,
АШИГЛАЛТЫН ТАЛААРХ СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ

2017 оны 05 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Д/д	Байршлын талаарх мэдээлэл		Ашиглалтын талаарх мэдээлэл			Тайлбар
	Байршил		Ашиглалтын байдал.	Хариуцагч байгууллага, нэгж	Түрээсийн орлого /сараар/ /мян.төг/	
1.	Сүхбаатар дүүрэгт 4 байршилд	17 дугаар хороо, Дамбадаржаа хийдийн хашаан дотор	Үйл ажиллагаа зогссон	-	-	
2.		8 дугаар хороо, Сүхбаатарын талбайн Хонхтой цэцэрлэгт	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	300,000	Түрээсийн гэрээ сунгагдаагүй.
3.		11 дүгээр хороо, 100 айл	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	300,000	2017 он дуустал түрээсийн гэрээтэй
4.		8 дугаар хороо, УБ зочид буудал	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	189,000	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй
5.		Сонгино- хайрхан	13 дугаар хороо, СХД-ЭМНэгдэл	Хэвийн ажиллагаатай байгаа	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	-

6.	дүүрэгт 4 байршилд	5 дугаар хороо, Саппоро автобусны буудал	Хэвийн ажиллагаатай байгаа	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	-	
7.		8 дугаар хороо, Баянхошууны тойргийн автобусны буудал	Хэвийн ажиллагаатай байгаа	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	-	
8.		27 дугаар хороо, СХД-ЗДТГ	-	-	-	Цахилгааны КТП-г улсын комисс хүлээж аваагүй.
9.	Баянгол дүүрэгт 3 байршилд	16 дугаар хороо, Баруун 4 зам	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	189,000	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй
10.		1 дүгээр хороо, Төмөр зам авто вокзал	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	189,000	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй
11.		13 хороо, Өргөө кино театр	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	189,000	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй
12.	Баянзүрх дүүрэгт 3 байршилд	3 дугаар хороо, Зүүн 4 зам	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	189,000	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй
13.		16 дугаар хороо, Батлан хамгаалахын их сургуулийн хашаан дотор	Үйл ажиллагаа зогссон	-	-	-
14.		8 дугаар хороо, Ботаник автобусны буудал	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	189,000	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй

15.	Чингэлтэй дүүрэгт 4 байршилд	18 дугаар хороо, 7-н буудал	Хэвийн ажиллагаатай байгаа	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	-	-
16.		16 дугаар хороо, Хайлаастын эцэс	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	0	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй боловч түрээсийн орлого авдаггүй.
17.		15 дугаар хороо, Чингэлтэйн эцэс	-	-	-	2017 онд НӨХГ-аас ХТГ-т ашиглалтад эцэслэн хүлээлгэж өгнө.
18.		2 дугаар хороо, Бөмбөгөр худалдааны төв	Хэвийн ажиллагаатай байгаа	Түрээсэлдэг	300,000	2017 он дуустал ашиглалтын гэрээтэй
19.	Хан-Уул дүүрэгт 1 байршилд.	1 дүгээр хороо, 120 автобусны буудал	Хэвийн ажиллагаатай байгаа	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	-	Ажиллаж байгаа
Нийт					2,034,000	

ТАНИЛЦСАН:
АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
... оны ... дугаар сарын

Ц.РЭГЗЭДМАА

СУДАЛГАА ЖАГСААЛТ НЭГТГЭСЭН:
АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТУУЛ